LOS ANGELES ТОЙРОГ БҮРТГЭГЧ-ТЭМДЭГЛЭГЧ/ТОЙРГИЙН АЖИЛТАН

ЦЭРГИЙН БОЛОН ХИЛИЙН ЧАНАД ДАХЬ СОНГОГЧИД

Цэргийн алба хааж байгаа эсвэл АНУ-аас гадуур амьдарч байгаа сонгогчдод сонгуульд оролцох нь урьд өмнөхөөсөө илүү дөхөм болсон. Энэ нь таныг цэргийн болон хилийн чанад дахь сонгогчоор бүртгүүлэх сонгуулийн материалыг шуудан, факс, цахим шуудангаар хүлээн авах үед эхэлнэ.

Та эрхтэй юу?

Та цэргийн болон хилийн чанад дахь сонгогчоор бүртгүүлэх эрхтэй эсэхээ мэдэхийн тулд дараахийн аль нэг нь байх ёстой:

АНУ-ын зэвсэгт хүчний идэвхтэй буюу нөөцийн гишүүн

Зэвсэгт хүчинд ажиллаж байгаа хүний эхнэр, нөхөр, асран хамгаалагч

НУ эсвэл КД-ийн нутаг дэвсгэрийн хилээс гадуур амьдардаг АНУ-ын иргэн.

(Цэргийн болон хилийн чанад дахь сонгогчийн статустай бүх өргөдөл гаргагч нь сонгогчийн бүртгэлийн шаардлагыг хангасан байх ёстой.)

1986 оны Холбооны ДХХЧИСӨТ хуулийн дагуу. Цэргийн/дүрэмт хувцастай алба хаагчид болон ажил эрхлэх, суралцах хөтөлбөр, цэргийн алба хаах шалтгаанаар АНУ эсвэл Колумбийн Дүүргийн нутаг дэвсгэрээс гадуур амьдарч буй АНУ-ын иргэд (армийн алба хааж байгаа нэгний эхнэр, нөхөр, асран хамгаалагчийг оролцуулан) хамрагдах боломжтой. Санал өгөхийн тулд бүртгүүлж, шуудангаар санал өгөх (эзгүй) саналын хуудас хүлээн авах хүсэлт гаргах эрхтэй. Энэ актыг Холбооны сонгуулийн тусламжийн хөтөлбөр хэрэгжүүлдэг.

Санал өгөхөөр бүртгүүлэх

Хэрэв та цэргийн болон хилийн чанад дахь сонгогчоор бүртгүүлэх эрхтэй бол дараах сонголтуудын аль нэгийг ашиглан бүртгүүлэх боломжтой.

Онлайн: Калифорнийн онлайн сонгогчдын бүртгэл эсвэл Холбооны сонгуулийн тусламжийн хөтөлбөр
Баримт бичиг: Калифорнийн Төрийн нарийн бичгийн даргаас ирүүлсэн сонгогчдын бүртгэлийн маягтыг бөглөж, дараах зүйлсийн аль нэгийг хийнэ үү.

- Маягтыг (562) 232-7925 эсвэл (877) 614-1128 руу **факсаар** илгээнэ.
- Маягтыг дараах хаягаар **шуудангаар** илгээнэ: Registrar-Recorder/County Clerk, Voter Records Division, P.O. Box 30450, Los Angeles, CA 90030-0450

Эрт эхлэх - Лос Анжелес Тойрог сонгуулийн өдрөөс 60 хоногийн өмнө цэргийн болон хилийн чанад дахь сонгогчдод саналын хуудсыг илгээж эхэлдэг. Санал өгөх материалаа цаг тухайд нь авахын тулд эрт бүртгүүлээрэй.

Асуулт байна уу?

LAVOTE.GOV руу зочлох эсвэл QR кодыг уншуулна уу